



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/АМЗ

Булган сум

Булган сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг дүгнэх үнэлгээний багийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны гэрээг хагас болон бүтэн жилээр дүгнэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:


Үнэлгээний багийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд	Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл
	Булган сумын иргэний төлөөлөл (зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн газрын анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Холбогдох хууль, журмын дагуу өрхийн Эрүүл мэндийн төвийн гэрээг хагас жилээр 2024 оны 07 дугаар сарын 03, бүтэн жилээр 2025 оны 01 дүгээр сарын 03-ны дотор дүгнэж, гэрээ байгуулсан талуудад дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж ажиллахыг үнэлгээний багт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр Doc/2024/Захирамж

0324010539